



**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ,
ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА
ЭРХЛЭГЧДИЙН 2023 ОНЫ III
ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар

1

САЛБАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2

БОРЛУУЛАЛТЫН ТОЙМ

3

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ҮЗҮҮЛЭЛТ**

4

ДҮГНЭЛТ



Товчилсон үгийн тайлал

1. Хороо-Санхүүгийн зохицуулах хороо
2. ҮМҮЧЭТХЭАЭ-Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч



Хүснэгт, дүрслэлийн жагсаалт

Хүснэгт 1. ҮМҮЧЭТХЭАЭ байриллаар

Хүснэгт 2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 3. Орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн тоо

Дүрслэл 2. ХЭ, ХНХ, оноосон нэр, салбар нээх хүсэлтүүдийн шийдвэрлэлт

Дүрслэл 3. ҮМҮЧ-ны арилжаа эрхлэгч иргэд байриллаар

Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)

Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Дүрслэл 6. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Дүрслэл 7. Худалдан авсан болон худалдсан үнэт металлын хэмжээ

Дүрслэл 8. Худалдан авсан болон худалдсан алтны хэмжээ

Дүрслэл 9. Худалдан авсан болон худалдсан мөнгөний хэмжээ



Бүртгэл, зөвшөөрлийн чиглэлд:

Тайлант улирлын байдлаар нэр бүхий 50 хуулийн этгээд, 461 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо болон иргэдийн тоо тус тус 5-аар нэмэгдсэн байна.

Мөн оны 1-3 дугаар улиралд тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдээс хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, салбар нээн ажиллуулах, эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийн тухай нийт 12 хүсэлт Хороонд ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид:

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид өссөн дүнгээр 1,793.3 кг үнэт металлыг 224,321,400.4 мянган төгрөгөөр худалдан авч, 1,891.7 кг үнэт металлыг 240,040,033.8 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.4 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.3 дахин өссөн үзүүлэлт юм.

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд өссөн дүнгээр 1,196.3 кг алтыг 222,766,546.2 мянган төгрөгөөр худалдан авч, 1,298.1 кг алтыг 238,296,944.6 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 1 дахин буурч, худалдан борлуулсан алтны хэмжээ 0.9 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь өссөн дүнгээр нийт 597.0 кг мөнгийг 1,554,854.3 мянган төгрөгөөр худалдан авч, 593.5 кг мөнгийг 1,743,089.2 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 7.5 дахин, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 10.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.


Хяналт шалгалт:

Тайлант улирлын байдлаар ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 50 хуулийн этгээд, 461 иргэдээс 1,054 арилжааны мэдээ, 146 санхүүгийн тайлан ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан.

Тайлант улиралын байдлаар Хороо үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч 43 иргэдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлж, нэр бүхий 4 иргэнд УБАШ, нэр бүхий 29 иргэнд зөвлөмж хүргүүлсэн.

Хорооноос 2023 оны 1-3 дугаар улиралд нэр бүхий 10 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэр бүхий 106 иргэний дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.


Тайлант хугацааны байдлаар Хороо өссөн дүнгээр нэр бүхий 50 хуулийн этгээд, 461 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоод байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо болон иргэдийн тоо тус тус 5-аар нэмэгдсэн үзүүлэлт юм. Зохицуулалттай этгээдүүдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан дүрслэл 1-д үзүүлэв. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд нь нийт 9 салбартай.




Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн тоо

Салбарууд нь Улаанбаатар хотод байршилтай.

Энэ оны 1-3 дугаар улиралд тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдээс хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, салбар нээн ажиллуулах, эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийн тухай нийт 12 хүсэлт Хороонд ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн. Эдгээр хүсэлтийг төрлөөр нь ангилан дүрслэл 2-т үзүүлэв.



Дүрслэл 2. ХЭ, ХНХ, оноосон нэр, салбар нээх хүсэлтүүдийн шийдвэрлэлт



Хорооноос 2023 оны 1-3 дугаар улиралд нэр бүхий 10 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэр бүхий 106 иргэний дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.

Тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгч иргэдийн 79.4 хувь буюу 366 иргэн Улаанбаатар хотод, 20.6 хувь буюу 95 иргэн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийг байршлаар нь ангилан хүснэгт 1-д үзүүлэв.

Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд
Сүхбаатар	5	8	6	13
Хан-Уул	0	9	3	12
Баянзүрх	5	7	11	3
Чингэлтэй	40	187	36	15
Баянгол	8	19	3	4
Сонгинохайрхан	6	12	1	2
Орон нутаг	8	8	79	1

Хүснэгт 1. ҮМҮЧЭТХЭАЭ байршлаар

Орон нутагт үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлж буй нэр бүхий 79 иргэнийг байршлаар нь ангилан дүрслэл 3-д үзүүлэв.

Сэлэнгэ	22	Говь-Алтай	3
Баянхонгор	15	Увс	2
Төв	14	Дорноговь	1
Дархан-Уул	11	Өвөрхангай	1
Өмнөговь	5	Дорнод	1
Ховд	4		


Дүрслэл 3. ҮМҮЧ-ны арилжаа эрхлэгч иргэд байршлаар

Орон нутагт үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхэлж буй 8 иргэн нь Өмнөговь, Говь-Алтай, Дархан-Уул, Хэнтий, Увс аймгуудад тус тус байршилтай.

Мөн үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 8 иргэн нь Дархан-Уул, Ховд, Баянхонгор аймгуудад тус тус үйл ажиллагаа эрхэлж байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгө



Тайлант улирлын байдлаар ҮМҮЧЭТХЭАЭ 50 хуулийн этгээд нь 82 хувьцаа эзэмшигчийн 9,604,449.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 7-оор нэмэгдсэн бол, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)


Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 50 хуулийн этгээдийн 9,604,449.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 54.5 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 45.5 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалтын эзэлж буй хувийг улсаар нь ангилан дүрслэл 5-д үзүүлэв.




Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Тусгай зөвшөөрөлтэй 50 хуулийн этгээдийн 31 нь 1 хувьцаа эзэмшигчтэй, 13 нь 2 хувьцаа эзэмшигчтэй, 6 нь 3 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдийг хувьцаа эзэмшигчдийн тоогоор нь ангилан дүрслэл 6-д үзүүлэв.




Дүрслэл 6. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 1,793.3 кг үнэт металлыг 224,321,400.4 мянган төгрөгөөр худалдан авч, 1,891.7 кг үнэт металлыг 240,040,033.8 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.4 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.3 дахин өссөн үзүүлэлт юм.




Дүрслэл 7. Худалдан авсан болон худалдсан үнэт металлын хэмжээ

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 1,196.3 кг алтыг 222,766,546.2 мянган төгрөгөөр худалдан авч, 1,298.1 кг алтыг 238,296,944.6 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 1 дахин буурч, худалдан борлуулсан алтны хэмжээ 0.9 дахин өссөн байна.



Дүрслэл 8. Худалдан авсан болон худалдсан алтны хэмжээ

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 597.0 кг мөнгийг 1,554,854.3 мянган төгрөгөөр худалдан авч, 593.5 кг мөнгийг 1,743,089.2 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 7.5 дахин, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 10.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.



Дүрслэл 9. Худалдан авсан болон худалдсан мөнгөний хэмжээ



Үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжааны мэдээ

Борлуулалтын тойм

* Тайлант улирлын байдлаар зохицуулалттай этгээдүүд өссөн дүнгээр 13,447,726.9 мянган төгрөгийг үнийн дүн бүхий үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийг худалдан авсан бол 20,382,554.3 мянган төгрөгийн үнийн дүн бүхий үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийг худалдан борлуулсан байна.



Шигтгээ

* Монголбанк 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 529 аж ахуйн нэгж болон иргэдээс 13,339.8 кг алтыг 2,023,795,479.9 мянган төгрөгөөр худалдан авсан байна.



Хүснэгт 2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.III	Нийт хөрөнгөд эзлэх хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,977,683.5	24.5%
Дансны авлага	2,518,330.8	4.4%
Татвар, НДШ – ийн авлага	461,800.9	0.8%
Бусад авлага	1,089,910.2	1.9%
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	23,063,867.3	40.3%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,932,443.3	5.1%
Бусад эргэлтийн хөрөнгө	451,245.6	0.8%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,756,445.3	3.1%
Эргэлтийн хөрөнгийн дүн	46,251,727.3	80.9%
Үндсэн хөрөнгө	10,148,689.2	17.8%
Биет бус хөрөнгө	304,748.8	0.5%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	407,374.1	0.7%
Хойшлогдсон татварын хөрөнгө	34,450.1	0.1%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	14,000.0	0%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,909,232.3	19.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	57,160,989.2	100%
Дансны өглөг	14,261,859.2	24.9%
Цалин, татвар, НДШ-ийн өглөг	1,332,528.3	2.3%
Банкны богино хугацаат зээл	2,416,132.1	4.2%
Хүүний өглөг	784,015.0	1.4%
Ногдол ашгийн өглөг	675,000.0	1.2%
Урьдчилж орсон орлого	1,371,563	2.4%
Нөөц /өр төлбөр/	15,067.7	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	5,292,045.6	9.3%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	26,147,940.9	45.7%
Урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат зээл	5,050,516.4	8.8%
Хойшлогдсон татварын өр	3,718.1	0%
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,054,234.6	8.8%
Өр төлбөрийн нийт дүн	31,202,715.5	54.5%
Өмч	9,604,449.1	16.8%
- хувийн	9,604,449.1	16.8%
Нэмж төлөгдсөн капитал	2,278,232.1	4%
Халаасны хувьцаа	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	288,263.9	0.5%
Эздийн өмчийн бусад хэсэг	1,455,879.9	2.6%
Хуримтлагдсан ашиг	12,331,988.8	21.6%
Эздийн өмчийн дүн	25,958,813.8	45.5%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	57,160,989.2	100%



Эргэлтийн
хөрөнгө

80.9%

19.1%

Эргэлтийн
бус хөрөнгө

Өр төлбөрийн
нийт дүн

54.5%

45.5%

Эздийн
өмчийн дүн



Тайлант улирлын байдлаар зохицуулалттай этгээдүүд нь 57,160,989.2 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна. Нийт хөрөнгийн 80.9 хувь буюу 46,251,727.3 мянган төгрөгийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаа бол 19.1 хувь буюу 10,909,232.3 мянган төгрөгийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант улирлын байдлаар зохицуулалттай этгээдүүдийн өр төлбөр ба эздийн өмчийн дүн 57,160,989.2 мянган төгрөгийн 54.5 хувь буюу 31,202,715.5 мянган төгрөгийг өр төлбөрийн нийт дүн, 45.5 хувь буюу 25,958,813.8 мянган төгрөгийн эздийн өмчийн дүн тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид нь 20,352,977.3 мянган төгрөгийн хуримтлагдсан ашигтайгаар үйл ажиллагаа эрхэлжээ.

Нийт орлого

32,453,499.9 мянган төгрөг

Борлуулалтын орлого

31,980,352.2 мянган төгрөг

Нийт зардал

26,371,884.5 мянган төгрөг

Цэвэр ашиг **6,081,615.4**

мянган төгрөг

Үзүүлэлтүүд

2023.III

Нийт орлого	100%
Борлуулалтын орлого (цэвэр)	98.5%
Бусад орлого	1.5%
Нийт зардал	100%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	65.1%
Борлуулалт, маркетингийн зардал	14.7%
Ерөнхий ба удирдлагын зардал	15.3%
Санхүүгийн зардал	1.5%
Бусад зардал	0.6%
Татварын зардал	2.3%
Бусад гарз	0.5%
Тайлант үеийн цэвэр ашиг	6,081,615.4

Хүснэгт 3. Орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

* Тайлант улирлын байдлаар үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид нь 32,453,499.9 мянган төгрөгийн нийт орлоготой, 26,371,884.5 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлжээ.

* Ингэснээр зохицуулалттай этгээдүүд нь тайлант үед 6,081,615.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.


* Нийт орлогын 98.5 хувийг борлуулалтын орлого, 1.5 хувийг бусад орлого эзэлж байгаа бол нийт зардлын 65.1 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 15.3 хувийг ерөнхий ба удирлагын зардал, 14.7 хувийг борлуулалт маркетингийн зардал, үлдсэн 4.9 хувийг бусад зардлууд тус тус эзэлж байна.



Бодлого, зохицуулалтын орчин

Хорооны 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 233 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталсантай холбогдуулан арилжаа эрхлэгчдээс ирүүлэх санхүүгийн тайлан болон арилжааны мэдээний мастер файлыг боловсруулж, тайлан нэгтгэлийн ФинА системд метадатаг өрж, журмын хэрэгжилийг хангуусан.

Тус журмаар ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь улирал бүрийн дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор холбогдох тайлан мэдээг Хороонд тайлагнах нөхцөл бүрдсэн.

 <p>ЦАХИМ ТАЙЛАН</p>	<p>Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч</p> <p>/Улирал бүр/</p>	<ul style="list-style-type: none"> • Арилжааны мэдээ • МАСТЕР ФАЙЛ TATAХ • Санхүүгийн тайлан • МАСТЕР ФАЙЛ TATAХ
---	--	--




Санхүүгийн зохицуулах хороонд Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO27001 стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай бэлтгэл ажил хангах ажлын хэсэгт орж, ажиллаж байна.



ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 198 иргэнд хүртээмжтэй санхүү танхимд сургалт зохион байгуулж, хичээл заав.

Хамтын ажиллагаа



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гарц шийдлийг хэлэлцэх, оролцогч байгууллагуудын ойлголтыг нэгтгэх зорилгоор нэр бүхий 4 төрийн байгууллага, (Монголбанк, Эрүүгийн цагдаагийн алба, Экологийн цагдаагийн алба, Ашигт малтмал, газрын тосны газар) 3 мэргэжлийн холбоодын төлөөлүүдтэй уулзалт зохион байгуулав.



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэгт оролцов.



САНГИЙН ЯАМ

Сангийн яамнаас зохион байгуулсан "Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ)-ийн сургалтад хамрагдаж, холбогдох саналыг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр хүргүүлсэн.

Хорооноос баталсан хөтөлбөрийн дагуу Холбооны зохион байгуулах сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулах ажлын хүрээнд холбогдох албан хаагчид хичээлийн видео бичлэгийг хийлгэсэн.






Бодлого зохицуулалтын орчин



Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль бус уул уурхайн эрх зүйн зохицуулалтын талаар Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон холбогдох нэр бүхий төрийн байгууллагууд, Азийн сангийн хамтарсан уулзалтад оролцож, санал солилцсон.

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 198 иргэнд Хорооны 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 11/2011 тоот мэдэгдлийг хүргүүлсэн. Үүний дагуу 3 удаагийн 67 иргэнд СЗХ-ны хүртээмжтэй санхүү танхимд сургалтыг танхимаар зохион байгуулж, хичээл заасан.



“Хууль бус уул уурхай, асуудал шийдэл” хэлэлцүүлэгт оролцов.

Олон нийтийн үйл ажиллагаа



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Mongolian jewellery and metal-2023” арга хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ҮМҮЧЭТХЭАЭ-ийн зохицуулалт, хууль, эрх зүйн орчны талаарх зөвлөгөө, мэдээллийг 500 орчим иргэн, хуулийн этгээдэд хүргэж ажиллав.

Монгол улсад Стандарт, хэмжил зүйн салбар үүсэж хөгжсөний 100 жил, Сорьцын хяналтын газрын 60 жилийн ойг тохиолдуулан иргэд олон нийтэд санхүүгийн боловсролыг олгох, төрийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготойгоор 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэж, ажиллав.



Тайлант улирлын байдлаар ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 50 хуулийн этгээд, 461 иргэдээс 1,054 арилжааны мэдээ, 146 санхүүгийн тайлан ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан.




Зөвлөмж (хуулийн этгээд)

49



ТЗ-ийг түдгэлзүүлэх тухай мэдэгдэл

206



УБАШ

4

Тайлант улирлын байдлаар Хороо үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч 41 иргэдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлж, нэр бүхий 4 иргэнд УБАШ, нэр бүхий 29 иргэнд зөвлөмж хүргүүлсэн.



Зөвлөмж (иргэд)

29

Газар дээрх хяналт шалгалтад хамрагдсан 41 иргэний 67.4 хувь буюу 29 иргэн нь Баянхонгор аймагт, 32.6 хувь буюу 14 иргэн нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Баянхонгор аймагт үйл ажиллагаа эрхэлж буй “Баруун бүс худалдааны төв”, “Баянхонгор их дэлгүүр”, “Буянтбогд худалдааны төв”, “Булган” төвүүдэд үзлэг хийж, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүй эрхэлсэн иргэдэд болон Хорооны төлөөлөгчдөд Зөвшөөрлийн тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Хорооны 2020 оны 150 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”, Хорооны 2023 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам” болон Зөвшөөрлийн цахим системд хүсэлт илгээх тухай сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд танхимаар зохион байгуулсан.

Тайлант хугацааны байдлаар Хороо нэр бүхий 50 хуулийн этгээд, 461 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоод байна.

Хорооноос 2023 оны 1-3 дугаар улиралд нэр бүхий 10 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэр бүхий 106 иргэний дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ 50 хуулийн этгээд нь 82 хувьцаа эзэмшигчийн 9,604,449.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 7-оор нэмэгдсэн бол, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 50 хуулийн этгээдийн 9,604,449.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 54.5 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 45.5 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 1,793.3 кг үнэт металлыг 224,321,400.4 мянган төгрөгөөр худалдан авч, 1,891.7 кг үнэт металлыг 240,040,033.8 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.4 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.3 дахин өссөн үзүүлэлт юм.

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 1,196.3 кг алтыг 222,766,546.2 мянган төгрөгөөр худалдан авч, 1,298.1 кг алтыг 238,296,944.6 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 1 дахин буурч, худалдан борлуулсан алтны хэмжээ 0.9 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 597.0 кг мөнгийг 1,554,854.3 мянган төгрөгөөр худалдан авч, 593.5 кг мөнгийг 1,743,089.2 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 7.5 дахин, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 10.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант улирлын байдлаар зохицуулалттай этгээдүүд нь 57,160,989.2 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна. Нийт хөрөнгийн 80.9 хувь буюу 46,251,727.3 мянган төгрөгийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаа бол 19.1 хувь буюу 10,909,232.3 мянган төгрөгийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

* Тайлант улирлын байдлаар үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид нь 32,453,499.9 мянган төгрөгийн нийт орлоготой, 26,371,884.5 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлжээ.

* Ингэснээр зохицуулалттай этгээдүүд нь тайлант үед 6,081,615.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.



Дүгнэлт

Тайлант улирлын байдлаар ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 50 хуулийн этгээд, 461 иргэдээс 1,054 арилжааны мэдээ, 146 санхүүгийн тайлан ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан.

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид нь 20,352,977.3 мянган төгрөгийн хуримтлагдсан ашигтайгаар үйл ажиллагаа эрхэлжээ.

Тайлант улиралд Хороо үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч 43 иргэдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлж, нэр бүхий 4 иргэнд УБАШ, нэр бүхий 29 иргэнд зөвлөмж хүргүүлсэн.

